

## ЖАЙНИЗМ ДАХЬ САПТА-БХАНГИ-НАЯА ОНОЛЫН АГУУЛГЫГ НЭХЭН СУРВАЛЖЛАХ НЬ

Б.Мөнхжавхлан (Ph.D)

Философи шашин судлалын тэнхим

ШУС, МУИС

**Түлхүүр үгс:** Бодит байдал, харьцангуйн тухай онол, жина, Анекантавада, Саптабханги-наяа, съядвада, ньядвада онол, жива, ажива, кевалажнана, шабда, тиртинкара.

**Товч утга:** Энэтхэгийн философи бодит байдлыг, түүнийг танин мэдэх асуудлыг өргөн хүрээтэй авч үзэж, тайлбарладагаараа өөрийн гэсэн онцлогтой билээ. Түүний онцлогийг шингээсэн философийн нэгэн систем болох жайнизм дахь харьцангуйн тухай онолыг энэхүү илтгэлд авч үзэж байгаа юм. Жайнизм “харьцангуй” хэмээх ойлголтыг онтологи, эпистемологийн аль аль хүрээнд хэрэглэсэн бөгөөд энэ нь тус философи чиглэлийн үзэл баримтлалын үндэс болсон байна. Энэхүү релятивист үзэл үнэний тухай асуудал, ухамсар, материйн харилцааны асуудлыг авч үзэхдээ “харьцангуй” хэмээх ойлголтыг хэрэглэсэн нь бодит байдлыг тайлбарласан өвөрмөц хандлага байсныг энд харуулахыг зорьсон болно.

\* \* \* \* \*

Сапта-бханги-наяа буюу Съядвада бол Жайнизм<sup>1</sup> дахь мэдлэгийн тухай сургаал юм. Жайнизм гэдэг үгийн этимологи утга нь *жина* буюу ялах дийлэх буюу хүслээ ялан дийлэх гэсэн байна. Энэ бол ертөнцийн юмс үзэгдэлд автах шунал, хүсэл зэргийг хэлдэг ажээ. Тэгэхээр хүн хүслээ ялан дийлэх ёстой бөгөөд улмаар хүслээс ангид чөлөөт байдлыг олж авахын тулд ёс суртахууны хатуу дэгт суралцах ёстой юм. Иймээс Жайнизмын ерөнхий агуулга ёс суртахууны шинжтэй бөгөөд үүнийг нь энэтхэгийн философид оруулсан гол хувь нэмэр гэж үнэлдэг.

Энэхүү илтгэлд тус философийн ёс суртахууны агуулгыг бус эпистемологийн үзэл баримтлалыг шинжлэн харуулахыг зорьсон. Учир нь тус философи чиглэлийн ерөнхий онцлог, гол сургаал болох ёс суртахууны үзэл баримтлал нь бодит байдлыг танин мэдэх зорилгод үндэслэдэг тул үүнд уялдан онтологи, эпистемологийн хувьд их өвөрмөц тайлбар хийдгээрээ алдартай. Бодит байдлын тухай үзлийн хувьд Буддизм дахь юмс эгшин эгшинд өөрчлөгддөг тухай санаа, Адвайта Веданта философи дахь тогтвортой мөнх ахуйн санаа хоёуланг нь нэгтгэсэн агуулгатай юм.

Жайнизмд бодит байдал нь адилсал, өөрчлөлт, нэгдмэл хийгээд олон талт байдал бүгдийг багтаан илэрдэг гэж үздэг. Бодит байдал нэгэнт ийм цогц шинжтэй учир түүнийг зөвхөн нэг талаас тайлбарлах боломжгүй ажээ. Ертөнцөд хязгааргүй олон субстанц байх

<sup>1</sup> ХТӨ V зууны тэртээ Энэтхэгт уламжлалт Ведийн агуулгын эсрэг үзэл баримтлал бүхий хоёр философи чиглэл бий болсны нэг нь Жайнизм юм. Энэ урсгал бие даан философийн систем болж боловсрохоос өмнө тус философи чиглэлийн үзэл санааг 23 гэгээнтэн гарган тавьсан гэж энэтхэгийн философийн бүтээлүүдэд дурдсан байдаг. Яджур Ведэд нэр нь дурдагддаг Ршабха, Ажитаната, Аристанеми нарын гурван гэгээнтний үзэл баримтлалыг системчилснээр нь Махавираг (ХТӨ 599-527) энэ философийн үндэслэгч гэдэг. Энэ философи чиглэл ёс зүй болон логикийн сургаалаараа алдартай. Үндсэн эх сурвалж бичиг нь Таттварт-адигама-сутра (*Tattvarth-adhigama-sutra*) бөгөөд ХТ III-V зууны орчим Шри Умашвати бичсэн гэдэг.

бөгөөд субстанц бүр өөрийн тусгай шинжүүдтэй. Энэ бол Анекантавада<sup>1</sup> (Anakentavada) буюу Жайнизмын метафизикийн онол юм. Анекантавадагаас Ньяадвада<sup>2</sup> (Nyadvada), Сьяадвада (Syadvada) гэсэн хоёр онол үүдэн гарсан бөгөөд эдгээр онол Жайнизмын онтологи, эпистемологийн үндсэн агуулга болж байдаг. Анекантавадаг шувуу гэж зүйрлэвээс дээрх хоёр нь жигүүр болно гэсэн нэгэн зүйрлэл бий ажээ. Объект маш олон шинжтэй, хүний мэдлэг хязгаартайн тул энэ ертөнцөд орших субстанцыг бүгдийг, мөн тухайн нэг субстанцын бүх шинжийг таньж, мэдэж чадахгүй юм. Ньяадвада нь бодит байдлын талаарх аналитик үзэл баримтлал бөгөөд бид объектыг шинжлэхдээ харьцангуй байдлаар л танин мэддэг гэж энэ үзэлд нотолдог. Бидний мэдлэг ийнхүү хэсгийн шинжтэй байдаг учир тухайн юмыг бүрэн мэдсэн мэдлэг биш юм.

Ньяадвадад бодомжийн долоон төрлийг авч үзэх бөгөөд эдгээр нь ч мөн бүгдийг нэгэн дор тайлбарлаж чадахгүй хэмээдэг ажээ. Энэхүү онтологи утга бүхий тайлбар “харьцангуйн онол” буюу *Сабтабханги-наая* (Saptanhangi-nāya) гэсэн эпистемологийн үзэл баримтлалтай холбогддог. Жайнистууд юмсыг илэрхийлж болох 7 замыг тайлбарласан байна. Энэхүү бодит байдлын олон янз илрэх байдлыг заан ба сохор хүмүүсийн тухай ёгтлолоор төлөөлүүлдэг билээ. Энэтхэгийн энэхүү ёгтлол ихээхэн алдартай. Урьд өмнө хэзээ ч зааны талаар сонсож байгаагүй сохор хэдэн хүн заанд хүрч, түүнийг ямар амьтан болохыг тодорхойлохыг оролддог. Хүн бүр зааны биеийн урт хошуу, сүүл, чих, их бие гэсэн ямар нэг хэсэгт хүрч юу гэж мэдрэгдсэнээр зааныг тодорхойлон дүрсэлжээ. Гэвч дүрслэл бүр нь өөр байсан тул тэд нэгдсэн нэг санаанд хүрч чадаагүйг энэ ёгтлол илэрхийлдэг. Мөн энэ ёгтлолын утга нэгэн адилаар бодит байдлын талаар авч үзсэн бусад философи үзэл баримтлалуудын талаар Жайнизмд шүүмжлэхдээ, бодит байдлын талаар реалист байр сууринаас авч үзэлгүй, зөвхөн нэг талаас авч үзсэнээ үнэн хэмээн батлахыг оролддог хэмээжээ.

Сьяадвада онол буюу эпистемологийн үзэл санаа дээрхээс улбаалж гарч ирдэг. Сьяадвада гэдэг нь *Сьяат* гэсэн үгээс гаралтай бөгөөд харьцангуй, магадгүй гэсэн утга бүхий үг байна. Хүний мэдлэг харьцангуй, хязгаарлагдмал байдаг учир түүнийг илэрхийлэх бодомжууд мөн хязгаарлагдмал юм. Үүнийг Жайнизм Сьяадвадын онол хэмээн нэрлэжээ. Анекантавада Жайнизмын метафизик агуулгыг илэрхийлдэг бол Сьяадвада логик, эпистемологийн агуулгыг илэрхийлнэ.

Харин энэхүү илтгэлийн үндсэн ойлголт болох Саптабханги-наая бол Сьяадвада хэмээх ойлголттой адил утгаар хэрэглэгддэг. Гэхдээ утгачилбал “Долоон мөрт бодомж”-ийн тухай бөгөөд нийтэд нь “харьцангуй мэдлэгийн тухай онол” гэж нэрлэдэг.

<sup>1</sup> Орчин үеийн ревизионистүүд Анекантавада үзлийг шинээр тайлбарлахдаа энэ бол плюрализм бөгөөд шашны хүлээцтэй, толерант байдлыг илэрхийлдэг хэмээн тайлбарлах болжээ.

<sup>2</sup> *Ньяад-вада нь юмсыг өөрийнх нь харилцаанд нь авч үзэж буйг илэрхийлдэг. Үнэн бол харьцангуй шинжтэй гэж үздэг. Ямар нэг зүйлийг олон талаас нь тодорхойлсны зөвхөн нэг талыг авч үзсэн хэсгийн мэдлэгийг наая гэдэг. Үүнийг илэрхийлсэн бодомжийг бас наая гэнэ.*

*Долоон Наая бий.*

1. *Naigama-naya: Универсал буюу түгээмэл, нэгж чанарыг нэгтгэн харах тухай*
2. *Samgraha-naya: нэгж чанарыг үгүйсгэн универсалыг онцлох байдал*
3. *Yuvahara-naya: универсалыг үгүйсгэн нэгжийг онцгойлон авч үзэх байдал*
4. *Rjusutra-naya: бодит байдлыг түр зуурын хэмээн үзэхдээ нэгжийг бүр задлан эгшинүүдэд хуваадаг.*
5. *Shabda-naya: үг илэрхийлж буй юмтайгаа зайлшгүй холбоотойг авч үздэг.*
6. *Samabhiruda-naya: ямарваа ойлголт үгийн үндсээсээ өөр утгыг илэрхийлэх байдал*
7. *Evmbhuta-naya: ойлголт утгаа бүрэн илэрхийлэх эсэхийг тодорхойлдог.*

**Саптабханги-наяа буюу “Долоон мөрт бодомж”**

1. **Syād-asti** — Харьцангуйгаар юм бол бодитой- "Relatively, a thing is real"
2. **Syād-nāsti** — Харьцангуйгаар юм бол бодитой бус- " Relatively, a thing is unreal "
3. **Syād-asti-nāsti** — Харьцангуйгаар юм бол бодит болоод бодитой бус " Relatively, a thing is both real and unreal"
4. **Syād-asti-avaktavya** — Харьцангуйгаар юм бол тодорхойлогдошгүй-" Relatively, a thing is indescribable"
5. **Syād-nāsti-avaktavya** — Харьцангуйгаар юм бол бодитой болоод тодорхойлогдошгүй " Relatively, a thing is real and is indescribable"
6. **Syād-asti-nāsti-avaktavya** — Харьцангуйгаар юм бол бодитой бус болоод тодорхойлогдошгүй " Relatively, a thing is unreal and indescribable"
7. **Syād-avaktavya** — Харьцангуйгаар юм бол бодит болоод бодитой бус, тодорхойлогдошгүй "Relatively, a thing is real, unreal and indescribable" гэжээ.

Саптабханги-наяа онолд, бид юмсыг танин мэддэг ба юмсын тухай бидний мэдлэг харьцангуй хийгээд тухайн нөхцөлдөө үнэн байдаг. Жишээ нь бид ширээ оршин байна гэхэд энэ ширээ нь модоор хийсэн, тодорхой өндөр, өргөн, урт, өнгөтэй байна гэсэн үг. Танин мэдэгчийнхээ хувьд би ширээг оршин байна гэж үзвэл тэрхүү ширээг тодорхой цаг хугацаанд, тодорхой орон зайд, тодорхой урт, өндөр, өргөнтэйгөөр, тодорхой субстанц бүхий байгааг л хүртэж байна. Гэхдээ энэ ширээ өөр орчинд яг энэ хэвээр оршин байж чадахгүй. Хэн нэгэн өөр газар яг энэ ширээ байхгүй гэж хэлэхэд мөн л тухайн нөхцөлдөө үнэн ярьж буй хэрэг мөн гэдгийг энд авч үздэг. Бид өөрийн өмнө нэгэн ширээ байна гэж төсөөлбөл, тэр ширээг зөвхөн нэг талаас нь л харж байна, арай өөр газраас харахад тэр ширээ яг өмнөхтэйгөө адил харагдахгүй. Энэ нь бид юмсыг харьцангуйн хүрээнд л мэдэж буйг илтгэж байна. Энэ жишээгээр уг онолын тайлбарлая.

**Сьяад асти-Харьцангуйгаар, юм бол бодитой** гэдгийг тайлбарлаваас, тухайн объект тодорхой орон зай эзлэн, тодорхой цаг хугацаа гэх мэт шинжүүдийг агуулж харьцангуйгаар бодитой оршин байна гэдгийг илэрхийлдэг. Гэхдээ бид ямар нэг зүйлийг тодорхойлохдоо бидний тодорхойлсноос өөрөөр тайлбарлах тайлбар бий гэдгийг ямагт санах хэрэгтэй.

**Сьяад насти- Харьцангуйгаар, юм бол бодитой бус** гэдэг нь, тухайн юм буюу объект харьцангуйгаар бодитой биш гэдгийг илэрхийлнэ. Энэ нь ширээ хоёр өөр газар, ижил цаг хугацаанд орших боломжгүй. Иймд бодомж съяд насти нь съяд асти-тай адил байна.

**Сьяад асти ка насти ка-Харьцангуйгаар, юм бол бодит болоод бодитой бус** Энд тодорхой объект нэг талаас бодитой, нөгөө талаас бодитой бусыг илэрхийлж байна. Ширээ оршин буй нь миний хувьд бодитой, гэтэл хэн нэгний хувьд яг адил дүр төрхтэй тийм ширээ өөр ерөөнд байхгүй буюу бодитой бус байна. Энэ байр суурь ч үнэн. Энд ямар нэг зөрчил байхгүй юм.

**Сьяад авактавам- Харьцангуйгаар, юм бол тодорхойлогдошгүй** Анекантавадад, ертөнц дээр хязгааргүй олон субстанц байх бөгөөд бүгд мөн хэмжээлшгүй олон тооны шинж чанартай гэдэг. Мөн хүний мэдлэгийг хязгаарлагдмал гэж үзнэ. Нэгэнт хүн хязгаарлагдмал мэдлэгтэй учир бид субстанцын тухай бүх асуудлыг танин мэдэж чадахгүй юм. Бид тухайн объектыг тодорхойлж байна гэж үзвэл энэ нь харьцангуй байдлаар тодорхойлж байна. Ингэхээр бид маш олон талыг нь мэдэхгүй байна гэсэн үг юм. Иймд

объектыг хэдий бид тодорхойлохыг оролдсон ч энэ бол ерөөсөө тэрхүү объектыг тодорхойлсон хэрэг биш мөн тодорхойлолт маань ч хангалттай бус байна. Ингэхээр бидний тодорхойлолт, тухайн объектийн талаар бүрэн биш, харьцангуй тодорхойлолт байна.

**Съяад асти ка авактавям-Харьцангуйгаар, юм бол бодитой болоод тодорхойлогдошгүй:** хэдийгээр объектыг оршихуйн хувьд нь тайлбарлахыг зорьсон ч бүх шинжийг нь хэлж чадахгүй. Ширээний өнгө, өндөр, өргөн зэргийг хэлж болох авч түүнээс олон өөр шинж түүнд байх боломжтой. Ингэхээр юм бол харьцангуй бодитой авч бүрэн тодорхойлогдошгүй юм.

**Съяад асти насти авактавям –Харьцангуйгаар, юм бол бодитой бус болоод тодорхойлогдошгүй:** Объектыг хэдий бид оршихуйн хувьд тодорхойлсон ч цаашид тодорхойлох хэсгүүд нь үлдсэн байх боломжтой. Иймд юм бодитой бус мөн тодорхойлогдошгүй байна.

**Съяад авактавям — Харьцангуйгаар, юм бол бодит болоод бодитой бус, тодорхойлогдошгүй:** Хэрэв бид объектыг бодитой гэж үзэх ахул өөр нэгэн объектыг бодитой бус хэмээж болно. Мөн объектын оршихуй болон эс оршихуйг өгүүлж байхад энэ аль аль нь харьцангуй шинжтэй байхад мөн л тодорхойлогдошгүй байна.


Тус бодомжуудыг ийнхүү авч үзээд бүгд баттай болоод үнэн гэж Жайнизмд үздэг.

Энд бусад философи чиглэлүүд шүүмжлэл тавьдаг. Тухайлбал буддизм, веданта чиглэлүүдэд, Съяадвада онол бол өөрөө өөртөө зөрчилтэй гэж дүгнээд харанхуй, гэрэл хоёр хэрхэн хамтдаа байх вэ гэсэн асуултад хангалттай хариулт өгч чадахгүй гэсэн байна. Шанкара хэлэхдээ бид халуун, хүйтэн агаарыг нэгэн зэрэг амьсгалж чадахгүйн адил энэ үзэл бол зөрчилтэй гэж шүүмжилсэн ажээ.

Энд дахин нэг асуулт гарч ирдэг нь бүхнийг танин баригч байдаг гэж үзэхэд харьцангуйн тухай энэ үзэл хэрхэн түүнд холбогдох вэ гэдэг тухай юм. Хэрэв мэдлэг хийгээд юмс бүгд харьцангуй байдаг гэж үзвэл энэ нь хэрхэн тийм хүний хувьд боломжтой вэ гэсэн асуудал гарч ирнэ. Энэхүү үзэл нь бодит байдлыг харьцангуй чанартай гэж үзээд түүнийгээ баталсан дээрх бодомжуудаар тайлбарлажээ. Энд нэгэн өвөрмөц үзэл уялддаг нь чөлөөлөгдсөн сүнс, түүний мэдлэгийн тухай асуудал байдаг. Яагаад гэвэл мэдлэг харьцангуй гэж үзсэн хэрнээ бүрэн мэдлэг эзэмших бололцоо бий тухай, тэр тусмаа бүхнийг мэдэх интуйтив мэдлэгийн<sup>1</sup> асуудлыг гарган тавьсан байна.

---

<sup>1</sup> Жайнизмд мэдлэгийн 5 төрлийг авч үздэг. Энэ нь 1. Авади буюу ердийн танин мэдэхүй бөгөөд ой дурсамж, танихуй, индукцийн мэдлэгийг нэрлэнэ. 2. Шрути буюу тэмдэг, символ, анхаарал, ойгохуй болон наая буюу юмсын утгад холбогдох мэдтэг, 3. Авади буюу орон зай, цаг хугацаанд орших юмсын тухай шууд мэдтэг, 4. Манаспарья буюу бусдын тухай бодол, 5. Кевала буюу төгс мэдтэг эдгээр болой.



Мэдлэгийн төрөлийг <sup>1</sup> тоочихдоо *кевалажнана* хэмээх ойлголтыг авч үздэг. “Кевалажнана бол мэдлэгийн хамгийн дээд төрөл бөгөөд цэвэр, төгс, шууд, даруй, интуитив, бүхнийг мэдэх тийм мэдлэг юм”<sup>2</sup>. Бүхнийг танин мэдэгч гэдэг бол тухайн нэг субстанц, түүний бүх шинж чанарыг бүгдийг нь мэдэж чадна гэсэн үг юм. Жайнизмд гэгээрсэн, бодит байдлыг танин мэдэж, чөлөөлөгдсөн сүнсийг *тиртинкара* гэдэг харин тэрхүү тиртинкара кевалажнанаг эзэмшсэн байдаг гэж үздэг.

Энэхүү мэдлэгийн асуудал улмаар тус философи чиглэлийн хожим энэтхэгийн шашин, соёл, ёс суртахууны сэтгэлгээнд хамгийн их нөлөө үзүүлсэн ёс зүйн үзэлд холбогддог. Өмнө дурьдсанчлан *жайн* гэдэг бол ертөнц хийгээд түүний юмст татагдах хүсэл, шуналаа тэвчин өөрийгөө ялах тухай байдаг. Жайнизм ёс зүйн тухай асуудлаа авч үзэхдээ юун түрүүнд хүний үүргийн асуудлыг авч үздэг. Хүний үүргийн хамгийн дээд нь хүчирхийлэлгүй байх явдлыг хүндлэх, хүчирхийлэл үйлдэхгүй байхыг энд сургадаг ажээ.

Жайнизмын үзэл ёсоор ертөнцөд буй юмс амьтай хийгээд амьгүй юмс буюу жива ажива гэсэн хоёр төрөл бий. Амьтай нь жива бөгөөд тоо томшгүй олон сүнс байдаг ажээ. Сүнсний дотоод мөн чанар бол хязгааргүй мэдлэг, тайван байдал, аз жаргал мөн. Матери нь атомоос бүрэлдэх бөгөөд тэрбээр сүнс орших нөхцөл нь болж байдаг. Амьд биесийн гол мөн чанар бол сүнс бөгөөд сүнсстэй байдаг учир хөдөлж байдаг. Сүнс өөрийг үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд биеийг өөртөө шаарддаг. Сүнс бол мөнх хийгээд бодитой байна. Хэрэв бие үгүй бол сүнс үйл ажиллагаагаа хэрэгжүүлж чадахгүй бөгөөд ямагт биеийг эрэлхийлж байдаг тул зовлонд автаж байдаг. Зовлонгоос ангижихаын тулд зөв, баттай мэдлэг хэрэгтэй, тиймээс сүнс Тиртинкарад итгэх ёстой аж. Энэ нь тус

<sup>1</sup> Мэдлэг: Шууд мэдлэг, шууд бус мэдлэгийг авч үздэг.

<sup>2</sup> Chatterjee, S., Datta, D. (1984). An Introduction to Indian Philosophy. Delhi. Calcutta Narayan Press. p.59

мэдлэгийн систем *шабда* буюу итгэмжийн мэдлэгийг хүлээн зөвшөөрч байдгийг илтгэж байна. Тиртинкара бол нэгэн цагт зовлонд автсан хүн байсан бөгөөд өөрийн хичээл, зүтгэл, итгэлээр зовлонгоос чөлөөлөгдсөн ажээ.

Үнэн зөв мэдлэг олж авахын тулд бидэнд үнэн мэдлэгт итгэх итгэл хэрэгтэй. Энд Самьяк мэдлэг буюу зөв мэдлэгийн тухай асуудал гарч ирнэ. Улмаар Тиртинкарагийн мэдлэг, туршлагад итгэсэнээр илүү хүчтэй итгэлтэй болж тэрхүү итгэлийн дагуу ёс суртахуунтай үйлийг хэрэгжүүлдэг. Энэ бол Жайнизмын гурван эрдэнэ буюу зөв мэдлэг, зөв итгэл, зөв үйл юм. Ийнхүү эдгээрийг хэрэгжүүлж чадсанаар энэ насандаа зовлонгоос чөлөөлөгдөх боломжтой ажээ.

Буддизмын нэгэн адилаар Жайнизм өөрийгөө шашин хэмээн үздэг боловч тэд бүтээгч бурхан тэнгэр хэмээх ойлголтыг авч үздэггүй. Ингэж буй шалтгаанаа дараахь байдлаар тайлбарладаг. Эхний шалтгаан нь хэрэв бурхан тэнгэр хэлбэргүй, биегүй аваас тэрбээр хэрхэн бүхий л орчлонг бүтээсэн байх вэ?, удаах нь хэрэв бурхан тэнгэр бүтээгч болоод мөнх бол ертөнцийг яагаад жигд хэвийн байлгадаггүй юм бэ энэ хоёр үндэслэлээр үгүйсгэдэг байна. Нэг талаасаа прагматик, нөгөө талаас үл хүчирхийлэх замыг сонгосон байдалтай онол байна. Яагаад прагматик үзэл хэмээв гэхээр бодит байдлын тухай танин мэдэхүйн хариулт болгож тухайн нөхцөл дахь харьцангуй буй мэдлэгийг чухалчилсан нь тус юмны тухай бүрэн бус мэдлэгийг мөн тухайн нөхцөлд нь хангалттай гэж үзсэн мэт байна. Гэхдээ шууд кевалажнана буюу төгс мэдлэгийн асуудлыг гаргаж ирсэн нь логик уялдаа багатай байгаа юм. Хүний мэдлэг хэдий хязгаартай ч өөрийгөө ялах чадвар бидэнд бий. Иймээс хүн чөлөөлөгдөх боломжтой гэж үзсэн нь энэ зөрчилт санааг шийдвэрлэх нэг хариулт болж байна. Илтгэлд дүгнэсэн прагматик мэдлэг гэсэн санааг үгүйсгэсэн тайлбар бас байна.

Өмнө дурдсан заан ба сохор хүмүүсийн тухай ёгтлол танин мэдэхүйгээс гадна ёс суртахууны үзэл баримтлалын нэг илэрхийлэл болдог. Хүн өөрийнхөө бодлоор үнэнийг батлахыг оролддог ч бусдын бодлыг хүлцдэггүйн дутагдлыг энд сануулж байдаг юм. Саптабханги-наая болон бодит байдлыг тайлбарлаж буй ерөнхий арга зүй нь зөрчлөөс зайлсхийсэн, бүхнийг харьцангуй үүднээс хүлээн зөвшөөрч байгаа нь уг онолын үзэл баримтлалыг хүлээцтэй, үл хүчирхийллээс ангид байдаг, ахимсаг номлодог гэж үнэлдэг байр суурьтай энэхүү илтгэлийн санаа нэгдэж байна. Энэ бүхнээс харахад Жайнизм дахь энэхүү мэдлэг хийгээд бодит байдал бол “харьцангуй шинжтэй” гэсэн тайлбар нь тус философи системийн агуулгыг практик, илүү ёс суртахуунлаг өвөрмөц болгож байгаа юм.

## НОМ ЗҮЙ

1. Chatterjee, S., Datta, D. (1984). An introduction to Indian Philosophy. Delhi. Calcutta Narayan Press.
2. Dasgupta, S. (2000). A History of Indian Philosophy, vol. 1, New Delhi: Motilal Banarsidas Publishers.
3. Hiriyanna, M. (1994). Outlines of Indian Philosophy. India.
4. Macdonell, A. A. (2002). A Vedic Reader for Students. New Delhi: Motilal Banarsidass Publishers.
5. Radhakrishnan, S. (2008). Indian Philosophy. New Delhi.

6. Radhakrishnan, S. (1992). Indian Philosophy (Centenary Edition. Volume Two). New Delhi.
7. Radhakrishnan, S., Moore, C. A.(1981).A Sourcebook in Indian Philosophy.United States of America.
8. Rao, N. (1976). Fundamentals of Indian Philosophy. India.
9. Sharma, C. (1983). A Critical Survey of Indian Philosophy. New Delhi: Motilal Banarsidas Publishers.
10. Vatsyayan, (1983). Indian Philosophy, New Delhi: Kedar Nath Ram Nath.

**Цахим эх сурвалж:**

<http://www.chaturpata-atharvan-ved.com/spiritual-books-section/spiritual-books/other-books/Tattvartha-Sutra-TR-By-Manu-Doshi-EN.pdf>

**ABSTRACT**

Indian philosophy has its own special feature that explains the reality and its knowledge broadly. In this paper, author considers theory of relativity in Jainism. The school of Jainism uses the term relativity, in terms of ontology and epistemology; therefore it becomes the ground of its philosophical view. This paper demonstrates the specificity of the tendency to explain reality with the concept of ‘relativity’.